



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/71

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.2.“а”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 12/09 дүгээр тогтоолыг тус тус дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Аймгийн төсөв батлах тухай” 12/09 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “2020 онд аймгийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, жагсаалтын 2 дахь заалтын дагуу Төрийн албанд автомашин худалдан авах, аймаг, сумдын төрийн байгууллагын автомашины засварын зардлыг хавсралтад заасны дагуу зарцуулсугай.

2. Төрийн байгууллагуудын авто машины засварт шаардагдах зардал 31.810.000 (гучин нэгэн сая найман зуун арван мянга) төгрөгийг 2020 оны аймгийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100153

Аймгийн Засаг даргын 2020 оны .08  
дугаар сарын .08-ны өдрийн /17/ дугаар  
захирамжийн хавсралт



АЙМАГ СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН АВТОМАШИНЫ ЗАСВАРТ  
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян төг/
1	Есөнзүйл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3580.0
2	Гучин-Ус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3560.0
3	Өлзийт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1190.0
4	Богд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1000.0
5	Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2880.0
6	Уянга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3000.0
7	Хархорин сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1000.0
8	Хайрхандулаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3000.0
9	Сант сумын Засаг даргын Тамгын газар	1600.0
10	Баянгол сумын Засаг даргын Тамгын газар	3000.0
11	Хужирт сумын Засаг даргын Тамгын газар	3000.0
12	Нарийнтээл сумын Засаг даргын Тамгын газар	5000.0
	НИЙТ ДҮН	31810.0

-оОо-